



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙНЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 63

Мандалговь

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
ээлжит дөрөвдүгээр хуралдаанаар
хэлэлцэх асуудлыг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 4-р хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд :

- 1.1. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай
- 1.2. Сумын 2021 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай
- 1.3. Сумын 2022 оны төсөв батлах тухай
- 1.4. Сумын 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлах тухай
- 1.5. Сумын 2021 оны бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг батлах тухай
- 1.6. Сумын зарим газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах, чөлөөлөх тухай
- 1.7. Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны ажлын тайлангийн тухай

2. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаанаар оруулах асуудлын шийдвэрийн төслийг сайтар боловсруулж, хуралдааны бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Б.Эрдэнэтуяа), сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Т. БАТЖАРГАЛ